



СОНГОГЧДЫН САНАЛ АВАХ, ТООЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА СОНГУУЛИЙН БАРИМТ БИЧИГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

www.gec.gov.mn



Санал авах газар, хугацаа

- Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаа
 - **6.10 – 6.11**-ний өдрүүдэд **07-22** цаг
- Зөөврийн битүүмжилсэн хайрцаг
 - **6.25** –ны өдөр **9-20** цагийн хооронд
- Санал авах байранд санал авах ажиллагаа
 - **6.26**-ны өдөр УБ-ын цагаар **07-22** цаг



Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогч:

- Санал авах байранд хүрэлцэн ирэх боломжгүй:
 - Эрүүл мэндийн байдлаас;
 - Нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа;
 - Захиргааны зөрчлийн улмаас саатуулагдсан, баривчлагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан;
 - Байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон;
- Санал авах ажиллагааг зохион байгуулж байгаа:
 - Сонгуулийн байгууллагын ажилтан
 - Цагдаагийн албан хаагч;
 - Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид;
 - МТ-ийн даамал.



Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах

- Үндэслэх баримт бичиг -
 - Сонгогчийн хүсэлт;
 - Эмнэлгийн магадлагаа ;
 - Холбогдох байгууллагын тодорхойлолт.



Хүсэлт гаргах хугацаа

2017.6.21-нээс өмнө

- Эрүүл мэндийн байдлаас хамаарсан бол:
 - Сонгогчийн хүсэлт, эмнэлгийн магадлагаа ;
- Дайчлагдсан, саатуулагдсан, баривчлагдсан болон санал авах ажиллагааг зохион байгуулахад оролцож байгаа бол:
 - Хүсэлтээ байгууллагын удирдлагад өгнө
 - Удирдлага нь тодорхойлолтын хамт САБ-нд өгнө.



Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах

- Нэрийн жагсаалт гаргана.
- Чиглэл, хуваарийг гарган батална.
- САБ-ны 2-оос доошгүй төлөөлөл сонгогчийн байгаа газарт нь очиж авна;
- 2-оос доошгүй, өөр өөр намын ажиглагч байлцуулна.



Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах

- Иргэний үнэмлэхийг үндэслэн саналын хуудас, дугтуйн хамт олгоно.
- Санал авч буй газарт нь:
 - Сонгогчийн гэрт бол гэр бүлийн гишүүн
 - Эмнэлэгт бол хүнд өвчтөн
 - Ажиглагч байлцахыг зөвшөөрнө.

× СНЖ-д ороогүй сонгогчийн саналыг ЗБСХ-аар авахыг хориглоно.



САНАЛ АВАХ ӨДӨР

- **2017.6.26 – Даваа гараг**
- Бүх нийтээр амарна.
- Энэ өдөр:

- ✗ согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах,
- ✗ соёл урлаг, үзвэр, спортын аливаа арга хэмжээ зохион байгуулах,
- ✗ гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг хориглоно.



Санал авч эхлэхийн өмнөх ажиллагаа

07.00 цагт САБ-ны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөлөл, ажиглагчдыг байлцуулан доорх ажиллагааг гүйцэтгэж тэмдэглэл үйлдэнэ.

1. СНЖ-д бичигдсэн сонгогчийн тоо /ЗБСХайрцаг/
2. Саналын хуудасны индекс, дугаар
3. Саналын хуудасны тоон үзүүлэлтүүд
4. Санал авах хайрцаг, төхөөрөмжийг шалган лацдах
5. ЗБСХайрцгийн саналын хуудсыг төхөөрөмжид уншуулах
/регистрийн дугаараар бүртгэлийн хуудас гаргуулах/
6. Тэмдэглэл хөтлөх- бүртгэлийн хуудас хавсаргана.
7. Ажиглагчдаар гарын үсэг зуруулна.



Сонгогч санал өгөх

1

- Хурууны хээ шалгуулна. /Иргэний үнэмлэх/
- Сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.

2

- Бүртгэлийн хуудас ➔ саналын хуудас , саналын хуудасны хавтас авна.
- СНЖ-д гарын үсэг зурна.

3

- Саналаа тэмдэглэнэ.
- Харааны бэрхшээлтэй иргэн - брайль

4

- Санал тоолох төхөөрөмжид хийнэ.
- Харааны бэрхшээлтэй иргэн – /итгэмжилсэн хүний туслалцаатай/



Саналын хуудас дахин олгох

- Сонгогч саналаа тэмдэглэхдээ алдаа гарган буруу тэмдэглэл хийсэн бол;
- Санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй бол

Нэгээс илүү нэр дэвшигчийн төлөө өгсөн
санал бүхий саналын хуудсыг

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ УНШИХГҮЙ.



Тэмдэглэл үйлдэх

- Санал авах өдрийн үйл ажиллагааны талаар ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛНӨ.



Санал хураалт дуусгах

- 22.00 цагт сонгогчийн бүртгэл зогсоно.
- Бүртгэлийн хуудас авсан сонгогчийг санал өгөх боломжоор хангана.



Санал тоолох

Санал хураалт дуусмагц

Ажиглагчид

**Хэвлэл мэдээллийн
байгууллагын төлөөлөгчид**



Санал тоолохоос өмнө:

**Санал өгсөн сонгогчийн тоо = саналын
хуудасны тоо /эцсийн тооцоо гаргана/
-Санал тэмдэглэх бүх үзгийг боож битүүмжилнэ**

**Зарцуулагдаагүй үлдсэн, сонгогч буруу
тэмдэглэл хийн хураалгасан саналын
хуудсыг хүчингүй болгон хайчилж,
битүүмжилнэ.**



Санал тоолох

Санал тоолох төхөөрөмжөөр тоолно.



Санал тоолох

- Төхөөрөмжөөс санал хураалтын үр дүнг ХЭВЛЭЖ авна.
 - ✓ Ажиглагчдад
 - ✓ СЕХ
 - ✓ Аймаг, нийслэлийн архив
- Төхөөрөмжөөс хэвлэгдсэн дүн нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна.
- Санал хураалтын дүнг хэвлэсний дараа үр дүнг нэн даруй МТТ-д дамжуулна.



Хориглоно:

- ✗ Санал тоолох цаг болоогүй байхад санал тоолуулах
- ✗ Санал хураалтын үр дүн дамжуулах ажиллагааг саатуулах, зогсоох.



Техникийн тооллого

/Хуулийн 97.13/

- Сум, дүүргийн сонгуулийн хороод санал хураалт дуусмагц сонгоно.
 - 50 хүртэл хувьд
 - 24 цагийн дотор явуулна.
- Техникийн тооллого хийсэн тухай нэгдсэн тайланг СЕХ-нд ирүүлнэ.

👉 АНХААРАХ ЗҮЙЛ:

- Төхөөрөмжид уншигдсан саналын хуудас бүр хүчинтэй.



Саналын хуудас битүүмжлэх

- Зориулалтын уутанд хийж битүүмжилнэ.
- Санал тоолохоос өмнө:
 - Зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудас
 - Сонгогч буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудас
- Санал хураалтын дүнг уншиж сонсгосны дараа:
 - Санал тоолох төхөөрөмжөөс гарсан саналын хуудас.
- Техникийн тооллого хийх эсэхээ мэдсэний дараа битүүмжилнэ.

АНХААРАХ ЗҮЙЛ:

-Битүүмжилсэн саналын хуудасны битүүмжлэлийг задалж болохгүй.
/зөвхөн шүүхийн шийдвэрээр/



Санал авах байрыг сонгох, бэлтгэх

- Сугалаа бэлтгэж, ажиглагчдад харуулсны дараа тусгайлан бэлтгэсэн хайрцагт хийнэ.
- Ажиглагчдаас төлөөлөл томилон сугалуулна.
- СДСХороо нь техникийн тооллого хийгдэхээр сонгогдсон санал авах байрны ахлах зохион байгуулагчид нэн даруй мэдэгдэнэ.



Техникийн тооллого хийх

- САБ санал хураалтын дүнг СЕХ-нд дамжуулсны дараа техникийн тооллогыг **нэн даруй эхлүүлж**, журамд заасан дарааллын дагуу **завсарлагагүйгээр**, ил тод, нээлттэй зохион байгуулна.

“Техникийн тооллого хийх журам”

/СЕХ-ны 2016.6.21-ний өдрийн

172 дугаар тогтоол/

- Ерөнхийлөгчийн сонгуульд

10, 11, 12 дугаар хавсралт



Үйл ажиллагааны дараалал:

1. Санал тэмдэглэх бүх үзгийг хураан авч, тусгайлсан сав, хайрцагт хийж битүүмжлэнэ.
2. МТ даамал нь санал авах, тоолох төхөөрөмжийн лацны бүрэн, бүтэн байдлыг шалган, ажиглагчдад харуулж, лацыг хөндөж, тэмдэглэлд тусгана.
3. МТ даамал санал авах, тоолох төхөөрөмжийг саналын хайрцгаас салгаж авна.
4. Саналын хуудсуудыг 25 ширхэгээр багцлан дугаарлана. Тухайн багц дахь саналын хуудсыг мөн дугаарлана.

Жнь: /1-1, 1-2, ... 1-25; 2-1, 2-2, ... 2-25; г.м/.



Үйл ажиллагааны дараалал:

5. Ахлах ЗБ саналын хайрцгаас гарсан нийт саналын хуудас /багцалсан/-ны тоо нь санал өгсөн сонгогчийн тоотой тохирч буй эсэхийг мэдээлнэ.
6. Ахлах ЗБ нэр дэвшигч нэг бүрийн авсан санал тус бүрийг багц тус бүрээр ажиглагчдад ил тод уншиж танилцуулна, /видео камер, телевиз эсхүл дэлгэц, проектор/
7. Нэр дэвшигч бүрийн авсан саналыг санал тус бүрээр нь тоолж, техникийн тооллогын хуудаст тэмдэглэнэ.
8. Багц тус бүрээр дүнг нэгтгэн техникийн тооллогын дүнгийн нэгтгэлд тэмдэглэн дүгнэнэ.
9. Техникийн тооллогын нэгдсэн дүнг гаргаж мэдээлнэ.



Тэмдэглэл хөтөлнө:

- Тэмдэглэлд САБ-ны бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Ажиглагчдаар тэмдэглэлд гарын үсэг зуруулж болно.
- Төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг тэмдэглэлд хавсаргана.



Ажиглагч

- Намын ажиглагч – 4 хүртэл
 - ✓ Санал авах өдрөөс 3 хоногийн өмнө хүсэлт гаргана.
- ТББ - 1 ажиглагч
 - ✓ Санал авах өдрөөс 3 хоногийн өмнө хүсэлт гаргана.
- Гадаадын ажиглагч – СЕХ

ХОРИГЛОНО:

- Төрийн албан хаагч ажиглагч байхыг хориглоно.



Ажиглагч бүртгэх

- 2016.6.23-наас өмнө /СТХ-107.8/
 - Ажиглагчаар томилсон шийдвэрийн хуулбар
 - Ажиглагчийн анкет
 - 1 хувь цээж зураг.
- ТББ – СЕХ-ны тогтоолоор
- Ажиглагчийн эрх, үүргийг нь танилцуулах.

Ажиглагч бүртгэлээс хасагдсан бол ажиглагчийн орны хүнийг томилох эрхгүй.



СЕХ-нд хүлээлгэн өгөх сонгуулийн баримт бичиг

1. Санал хураалтын дүнгийн нэгтгэл /аймаг, нийслэлийн дүүрэг/
2. Төхөөрөмжийн үр дүнгийн тайлан
3. Техникийн тооллого явуулсан талаарх нэгдсэн тэмдэглэл
4. Саналын хуудас хүлээн авсан мэдээ
5. Саналын хуудасны зарцуулалтын тайлан
6. Явцын мэдээ /маягтаар/ 12, 17, 22 цагт
7. Ирцийн мэдээ 12, 17, 22 цагт— тайлан хэвлүүлж авах
- СНЖ-д бүртгэгдсэн болон санал өгсөн иргэдийн
нас, хүйсийн судалгаа
8. Өргөдөл гомдлын талаарх мэдээлэл
9. Ажиглагчийн талаарх тоон судалгаа /хэсэг бүрээр/
10. Хийсэн ажлын дэлгэрэнгүй тайлан – хэсгээсээ авна.



САНАЛ ХУРААЛТЫН ЯВЦЫН МЭДЭЭ

Д/д	Аймаг, дүүргийн нэр	Иргэний бүртгэлийн байгууллагаас ирүүлсэн		12 цагийн байдлаар				17 цагийн байдлаар				22 цагийн байдлаар				Тайлбар
				Мэдээ ирүүлсэн хэсгийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдын		Мэдээ ирүүлсэн хэсгийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдын		Мэдээ ирүүлсэн хэсгийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдын		
		тоо	хувь			тоо	хувь			тоо	хувь			тоо	хувь	
ДҮН																

- САБ маягтын дагуу 12, 17, 22 цагуудад явцын мэдээг гарган СДСХороонд
- СДСХороо нь хэсгүүдийнхээ мэдээг нэгтгэн АНСХороонд
- АНСХороо нь сум, дүүргийн мэдээг нэгтгэн СЕХ-нд мэдээлнэ.



- САБ маягтын дагуу иргэний бүртгэлийн ажилтнаас тайлан хэвлүүлэн авна.
- СДСХороо нь тайланг ирцийн мэдээний нэгтгэлд хавсарган АНСХороонд
- АНСХороо нь сум, дүүргийн мэдээг нэгтгэн СЕХ-нд хүлээлгэн өгнө.



www.gec.gov.mn